



ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХУРАЛ

2017-03-13-ны өдөр аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн энэ оны гуравдахь удаагийн хурал хуралдаж дараах 9-н асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

1. “Чандмань Увс” ОНӨААТҮГ, ТУЗ-ийн 2016 оны тайлан хэлэлцэх, зөвлөмж чиглэл өгөх тухай
2. Увс аймгийн “Боловсролыг хөгжүүлэх хөтөлбөр” (2017-2020) батлах тухай
3. “Харганат”-ын төмрийн ордыг ашиглах тухай
4. “Дулааны II станц, дулааны иугам сүлжээ” ОНӨААТҮГ, ТУЗ-ийн 2016 оны тайлан хэлэлцэх, зөвлөмж чиглэл өгөх тухай
5. “Шинэ Улаангом” ОНӨААТҮГ, ТУЗ-ийн 2016 оны тайлан хэлэлцэх, зөвлөмж чиглэл өгөх тухай
6. “Таван тэсийн илч” ОНӨААТҮГ, ТУЗ-ийн 2016 оны тайлан хэлэлцэх, зөвлөмж чиглэл өгөх тухай
7. Орон нутгийн өмч, хөрөнгийн асуудлууд
8. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай
9. Шагналд тодорхойлох тухай



СУМДЫН ИТХ-ЫН ДАРГА, НАРИЙН БИЧГИЙН ДАРГА НАРЫН НЭГДСЭН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



Сумдын ИТХ-ын дарга болон, сумдын ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нарын нэгдсэн сургалт энэ сарын 16-17-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Уг сургалтын гол зорилго нь сумдын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарт аймгийн ИТХ-ын болон ГХУСА-ын 2017 онд хэрэгжүүлэх зорилтуудыг танилцуулах, хурлын дотоод ажил, цахим хуудас, бусад цаг үеийн ажлаар зөвлөмж, үүрэг чиглэл өгөхөд оришиж байгаа байгаа юм.

бичгийн дарга нарт аймгийн ИТХ-ын болон ГХУСА-ын 2017 онд хэрэгжүүлэх зорилтуудыг танилцуулах, хурлын дотоод ажил, цахим хуудас, бусад цаг үеийн ажлаар зөвлөмж, үүрэг чиглэл өгөхөд оришиж байгаа байгаа юм.

ОРОС ХЭЛНИЙ “Я ЛЮБЛЮ РУССКИЙ ЯЗЫК” УРАЛДААН АМЖИЛТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ

ОХУ-ын Тува улсын Парламент ба Увс аймгийн ИТХ-ын хамтын ажиллагааны хамтын ажиллагааны хүрээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулагдаг орос хэлний “Я люблю русский язык” уралдаан энэ өдрүүдэд зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан ОХУ-ын Тува улсын Дээд Хурлын /Парламентын/ төлөөлөгчид Улаангом хотноо ажиллалаа.



Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд ОХУ-ын Тува улсын Дээд хурлын /Парламент/ орлогч дарга, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Самойленко Ирина Петровна, Тува улсын Дээд хурлын нийгмийн бодлогын байнгын хорооны орлогч дарга Монгуш Ульяна Байырооловна, Тува Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын орлогч, орос хэлний улсын байцаагч Хардигов Елена Виктаровна, Тува улсын Дээд

хурлын нийгмийн бодлогын байнгын хорооны зөвлөх Грачева Ольга



Витальевна, Тува улсын Дээд хурлын орлогч даргын туслах Куулар Аржаан Геннадьевич болон бусад хүмүүс ирсэн байна. Төлөөлөгчдийг өнөөдөр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хүний хөгжил, нийгмийн асуудлын хорооны дарга

Т.Амарзаяа болон хорооны гишүүн аймгийн ИТХ-ын төлөөлөгч Э.Баатарсан, Д.Доржготов, С.Бямбабаатар, Б.Анхбаяр, Б.Алтанчулуун, Я.Алтангэрэл, ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Х.Даишэвэг нар хүлээн авч уулзан цаашидын хамтын ажиллагааны талаар дэлгэрэнгүй ярилцлага өрнүүлээ.

БАРУУН БҮСИЙН ЦАГДААГИЙН ХҮРЭЭНИЙ “МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ” СЭДЭВТ СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



Цагдаагийн ерөнхий газрын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Цагдаагийн ерөнхий газар, Увс аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Увс аймаг дахь цагдаагийн газраас хамтран баруун бүсийн

цагдаагийн хүрээний “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалт, зөвлөгөөнийг Улаангом хотноо зохион байгууллаа.

Зөвлөгөөнд баруун бүсийн аймгуудын Цагдаагийн газрын дэд дарга, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийн дарга, малын хулгай хариуцсан эрүүгийн төлөөлөгч, Увс аймгийн Цагдаагийн газрын сумдын цагдаагийн хэсгийн дарга, төлөөлөгч нар оролцсон бөгөөд зөвлөгөөний үеэр 2016 онд Говь-Алтай аймагт зохион байгуулагдсан мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх зөвлөгөөнөөс гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн танилцуулга болон аймаг бүрийн цагдаагийн газраас мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил, тэргүүн туршилага болон цаашид төлөвлөсөн ажлуудаа танилцуулсан юм.



СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНООС СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд Сонгуулийн Ерөнхий хорооноос байнгын бус ажиллагаатай сонгуулийн хороонд ажиллах ажилтнуудын сургалтыг хөдөө орон нутгуудад зохион байгуулж байгаа бөгөөд Увс аймагт СЕХ-ны мэдээлэл сурталчилгаа, арга зүйн хэлтсийн мэргэжилтэн Т.Гүенбаатар, Ө.Одсүрэн 03-р сарын 24-ний өдөр сургалтыг зохион байгууллаа. Уг сургалтанд 17 сумын 80 гаруй төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид хамрагдлаа.



**УИХ-ЫН ГИШҮҮН, ЗГ-ЫН ГИШҮҮН, САНГИЙН САЙД
Б.ЧОЙЖИЛСҮРЭН 2017 ОНЫ 03 САРЫН 27-31-НИЙ
ӨДРҮҮДЭД УВС АЙМАГТ АЖИЛЛАА**

УИХ-ын гишүүн, ЗГ-ын гишүүн, Сангийн сайд Б.Чойжилсүрэн 2017 оны 03 сарын 27-31-ний өдрүүдэд Увс аймгийн Гаалийн газар, Татварын хэлтэс зэрэг байгууллагууд болон Улаангом сумын багууд, хөдөөгийн 6 сумдад ажиллалаа.

Сайдын хамт Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн дарга О.Хуягцогт, Татварын ерөнхий газрын дарга Л.Зориг нар ажиллалаа.

Сангийн сайд Б.Чойжилсүрэн Монгол улсын эдийн засаг, төсөв,

санхүүгийн өнөөгийн нөхцөл байдал, цаашидын чиг хандлагын талаар иргэдэд дэлгэрэнгүй мэдээлэл өгч, тэдний



асуултад хариулж, санал бодлыг нь сонсож, уулзалт зохион байгуулав.

Тэрээр УИХ-ын 2016.11.24-ний өдрийн 01 дугаар тогтоолоор батлагдсан Эдийн засгийг сэргээх хөтөлбөр болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар, Монгол Улсын эдийн засгийн өсөлт сүүлийн жилүүдэд удааширч, төсөв төлбөрийн тэнцэлд алдагдал үүссэн бөгөөд ирэх онуудад бондын эргэн төлөлтүүд хийгдэхээр байгаа тухай, түүнчлэн гадаад, дотоод эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал, уул уурхайн хэт хамаарал, төсвийн сахилга бат, нэгдмэл байдал хангалтгүйгээс төсвийн алдагдал ихээхэн хэмжээгээр нэмэгдэж, үүнийг дагаад өндөр хүүтэй үнэт цаас гаргах замаар төсвийн алдагдлыг санхүүжүүлж байсан зэрэг нь Засгийн газрын өрийн хэмжээг оогцом нэмэгдүүлж, хүүгийн төлбөрийн дарамтыг өсгөснөөр төсвийн тэнцвэргүй байдлыг бий болгоод байгаа талаар ярьлаа.

**АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГТ ГЕМОДИАЛИЗ
ЭМЧИЛГЭЭНИЙ ТАСАГ НЭЭГДЛЭЭ**

Увс аймгийн Нэгдсэн эмнэлэгт Тайваний хөрөнгө оруулалтаар хоёр ширхэг Гемодиализ эмчилгээний аппарат тоног төхөөрөмжийг суурилуулан хүлээлгэж өгөх ёслол боллоо

Нээлтийн арга хэмжээнд Увс аймгийн ИТХ Дарга Э.Насанбат, Засаг дарга Д.Батсайхан НБХ дарга С.Амраа, ЭМГ-ын дарга Ц.Отгонбаяр, Нэгдсэн эмнэлэгийн дарга Д.Доржгатов болон Тайвань улсын



дутагдалтай өвчтөнүүд заавал хотод очиж өндөр зардлаар тус аппаратад орох шаардлагагүй болж байгаа юм.

БӨХМӨРӨН СУМ:

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал 2017 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хуралдлаа. Тус хурлаар



сумын Байгаль орчин тогтвортой хөгжлийн тасгийн 2016 оны ажлын үр дүн, 2017 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний тухай, Эрүүл мэндийн төвийн эмийн эргэлтийн сангийн 2016 оны ажлын тайлан, 2017 оны ажлын явц, цаашид хэрэгжүүлэх ажлын тухай Сумын нийтийн биеийн тамирын арга зүйч Э.Хосбаярын 2017 оны ажлын төлөвлөгөө, цаашид хийж хэрэгжүүлэх ажлын тухай асуудлыг авч хэлэлцсэн юм.

Хурлаар байгаль орчин тогтвортой хөгжлийн тасаг 2016 онд орон нутгийн орлогын бүрдүүлэлт хангалтгүй биелүүлсэн, зарим нэр төрлийн орлогын биелэлтийг тасалдуулсан зэрэг дутагдлыг анхааруулж, цаашид орон нутгийн орлогын бүрдүүлэлтийг сайжруулж, Бөхмөрөн сумын нутагт нутаглаж буй гадны сумдын малчин өрхөөс бэлчээр ашигласны төлбөр авах, Хотгор уурхайн айл өрхүүдээс хог, түши мод, байгалийн дагалдах баялаг ашигласны төлбөрийг тухай бүр бүрдүүлж, ажиллахыг үүрэг болголоо. Мөн сумын эмийн эргэлтийн сан нь тухайн жилийнхээ эмийн захиалгыг өгөхдөө өвчлөлийн талаар судалгаанд тулгуурладаггүй урд жилийнхээ захиалгыг харж таамгаар эм захиалдаг зэрэг дутагдал байгааг шүүмжлээд, эмийн захиалгыг өгөхдөө иргэдийн өвчлөлийн талаар суурь судалгаа гаргаж, ул үндэслэлтэй захиалгыг өгч байхыг үүрэг болголоо.

ЗАВХАН СУМ

Увс аймгийн Завхан сумын ИТХ,ЗДТГ Улаанбаатар хотын нутгийн зөвлөлийн дарга С.Хийморьсантай хамтран 2017.03.12-нд Тэмээний баярыг 13 дахь жилдээ зохион байгууллаа.

Тэмээний баярыг нээж нутгийн зөвлөлийн дарга С.Хийморьсан, сумын ИТХ-ын дарга Б.Энх-Амгалан, Засаг дарга Б.Пүрэвгончиг нар үг хэлсэн бөгөөд тэмээн прад, тэмээний уралдаан, тэмээтэй буухиа, гоё ганган тэмээтэй сайхан хос шалгаруулах зэрэг арга хэмжээнүүд явагдлаа. 54 тэмээ уралдсанаас Завхан сумын Шар булаг багийн малчин А.Баянмөнхийн хүрэн ат түрүүлээ. Тэмээтэй буухиа, ганган тэмээтэй хос шалгаруулах тэмцээнд Ховд аймгийн Дөргөн сумын тэмээчид түрүүлсэн.



Хаяг

Увс аймаг, Улаангом хот, 3-р баг
Ө.Бадрахын гудамж,
ЗДТГ-ын байр 210 тоот

Утас :70453627

Факс :70452214

И Мэйл:

info@khural.uv.gov.mn

Вэб сайт:

http://uvs.khural.mn/

Facebook:

Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал